



“Бүх нийт боловсролын төлөө!”

Иргэний нийгмийн үндэсний эвсэл

“ҮНДЭСТЭН/УГСААТНЫ ЦӨӨНХ” ХЭМЭЭХ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР



Улаанбаатар хот
2023 он




“Бүх нийт боловсролын төлөө!”

Иргэний нийгмийн үндэсний эвсэл

“ҮНДЭСТЭН/УГСААТНЫ ЦӨӨНХ” ХЭМЭЭХ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Улаанбаатар хот
2023 он



“ҮНДЭСТЭН/УГСААТНЫ ЦӨӨНХ” ХЭМЭЭХ НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- I. 1990-ээд оноос өмнөх үеийн “Үндэстэн/ угсаатан” хэмээх нэр томъёоны тухай (Хууль эрх зүйн баримт бичиг, судалгааны бүтээл, толь бичиг)
- II. 1990-ээд оноос хойшхи үеийн “Үндэстэн/ угсаатан” хэмээх нэр томъёоны тухай (Хууль эрх зүйн баримт бичиг, судалгааны бүтээл, толь бичиг)

I. 1990 оноос өмнөх үед үндэстэн болон угсаатан хэмээх нэр томъёог хэрхэн тэмдэглэж, тайлбарлаж байсныг танилцуулъя.

1924 оны “БНМАУ-ын Үндсэн хууль”-ийн 1-р бүлгийн 11-р зүйлд “Тус улсын харьяат ард түмэнд **угсаа**, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаваргүй нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”¹ хэмээн заажээ. Иймд уг хуульд үндэстэн, угсаатан хэмээх үгийн хэрэглэсэнгүй.

Харин 1940 оны “БНМАУ-ын Үндсэн хууль”-ийн 2-р бүлгийн 10-р зүйлийн 8-д “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын доторхи **яс үндэстнүүдийн** улс төр, аж ахуй, соёл, боловсролын хөгжилтийг **тэдгээрийн үндэсний** онцлог байдалтай тохируулан хангах”, 9-р бүлгийн 71-р зүйлд “БНМАУ-ын харьяат 18 насанд хүрсэн бүр иргэд нь эрэгтэй, эмэгтэй, шашин шүтлэг, **яс үндэс**, эрдэм чадвар, нүүдлийн буюу суурьшлын байдал, эд хөрөнгийн байдлыг ялгаварлахгүй”, 81-р зүйлд “БНМАУ-ын харьяат 18 насанд хүрсэн ард иргэд эрэгтэй, эмэгтэй, арьс өнгө, **үндэстэн**, шашин шүтлэг, эрдэм боловсрол, нүүдэл суурьшил, хөрөнгийн байдал, нийгмийн гарлыг ялгалгүйгээр”, 10-р бүлгийн 92-р зүйлд “БНМАУ-ын бүх ард иргэн нь тус улсын засаг төр, аж ахуй, нийгэмлэг, улс төр, соёлын бүх салбарт **угсаа үндэстэн** ялгаварлахгүй тэгш эрх эдэлнэ”² хэмээснээс үзэхэд тухайн үед хуулинд “яс үндэстнүүд”(тэдгээрийн үндэсний онцлог), “яс үндэс”, “үндэстэн”, “угсаа үндэстэн” хэмээх үгийг албан ёсоор хэрэглэж эхэлсэн ажээ. Дашрамд тэмдэглэхэд дээд дурдсан “тэдгээрийн үндэсний” хэмээснийг өөр нэгэн эхэд “тэдгээрийн **үндэстний**”³ хэмээн зөрүүтэй бичсэн байна.

1960 оны “БНМАУ-ын Үндсэн хууль”-ийн 7-р бүлгийн 76-р зүйлд “БНМАУ-ын иргэд эрэгтэй, эмэгтэй, арьс, **үндэс**, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрхтэй”, 81-р зүйлд “БНМАУ-ын 18 насанд хүрсэн бүх иргэн нийгмийн гарал, байдал, арьсны өнгө, **яс үндэс**, эрэгтэй эмэгтэй, хэл, боловсрол, шашин шүтлэг, эрхэлсэн ажлын төрөл, эд хөрөнгийн байдал, ялгаваргүйгээр сонгох, сонгогдох эрхтэй”, 83-р зүйлд “БНМАУ-ын иргэд **яс үндэс** ялгаваргүй улс орныхоо төр, аж ахуй, соёл, нийгэм- улс төрийн бүх ажилд тэгш эрхтэй оролцоно. Арьс, **үндэс** ялгаварлаж дээрэнгүй, үндсэрхэх үзэл гаргаж, иргэдийн эрхийг шууд буюу шууд бусаар хязгаарлахыг хуулиар хориглоно. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа **бүх үндэстэнд** үндэсний соёлыг хөгжүүлэн төрөлх хэлээрээ суралцах, ажил хэргээ явуулах бололцоог улсаас олгоно”⁴ хэмээн заажээ. Иймд тухайн үед “яс үндэс”, бүх үндэстэн” хэмээх үгийг хэвээр, “үндэс” хэмээх үгийг шинээр хэрэглэж, өмнөх хуулинд хэрэглэж байсан “угсаа үндэстэн” хэмээх үгийг хэрэглэхгүй болсон байна.

Тэгвэл эдгээр ойлголтыг нийгэм, хүмүүнлэгийн ухааны бүтээлүүдэд хэрхэн тодорхойлон тайлбарлаж байсныг үзье.

1 Монгол улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд/1924-1992/.УБ., 1998.т.5.

2 Мөн тэнд. т. 15, 38, 39, 41.

3 1940 оны Үндсэн хууль: түүх, эрх зүйн асуудал. УБ.,2016.т.95.

4 Мөн тэнд. т.66, 67, 68,69.

1983 онд хэвлэгдсэн толь бичигт “**Үндэстэн** гэдэг бол хүмүүсийн нийтлэгийн түүхэн хэлбэрүүдийн нэгэн бөгөөд капитализмын үед үүсэн бий болжээ. Нэгдмэл нэг хэл, соёл зан заншилтай, нэг газар нутаг дээр амьдардаг, гаалийн нэгэн системтэй ард түмнийг үндэстэн гэж нэрлэнэ. Үндэстэнд газар нутаг, хэл, соёлын, ястанд байдаг нийтлэгээс гадна эдийн засгийн нийтлэг бүрэлддэг байна. Үндэстнийг бүрэлдүүлэгч нэгэн чухал шинж бол эдийн засгийн нийтлэг юм”⁵ хэмээн тодорхойлжээ.

1980 онд ЗХУ-д хэвлэгдсэн толь бичигт “Ястан бол овог, аймгийн нийтлэгийн түүхэн ёсны үргэлжлэл болж хүй нэгдлийн байгуулал хувийн өмчийн харилцаагаар солигдон, ангиуд үүсэн хөгжсөн нөхцөлд янз бүрийн аймгууд нийлэн нэгдэх замаар бүрэлдсэн хүмүүсийн нийтлэгийн нэгэн хэлбэр”⁶ хэмээн тодорхойлсон байдаг.

Харин БНМАУ-ын үндэстэн, угсаатны асуудлыг тусгайлан судалсан эрдэмтэн бол доктор С.Бадамхатан бөгөөд түүний бүтээлээс дэлгэрэнгүй танилцуулна. Тэрбээр “Манай улс голчлон нэг гарал угсааны **ястнуудаас** бүрдсэн болохоор үндэсний ба угсаатны хөгжлийн явц нь хоорондоо бараг үл ялгагдах мэт боловч үндэсний хөгжлийн хүрээнд угсаатны нэгдэл нь өөрийн хөгжлийн зүй тогтлын дагуу явж, харилцан хоорондоо диалектик холбоотой, бие биендээ үйлчлэх хүчин зүйл болдог юм. Үндэстэн ба угсаатны ойлголтын хоорондын үндсэн ялгаа нь:

1. Үндэстэн нь таваарын үйлдвэрлэл, дотоодын зах зээл үүсэхтэй уялдан капиталист, феодалын нийгмийн үед ч байсан.
2. Үндэстэн бүрэлдэн тогтох объектив эх сурвалж нь тусгаар тогтнолын төлөө үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, түүний улс төрийн удирдан чиглүүлэгч хүчин болдог бол угсаатан нь гарал угсаа, хэл, соёлын нийтлэг нэгдэлд үндэслэн бүрэлддэг.
3. Социалист нийгмийн үед үндэсний хөгжлийн явц нь нийгэм-эдийн засгийн нэгдмэл байдал, түүний хэтийн зорилтоор тодорхойлогдог бол угсаатны хөгжил нь ястан үндэстнүүдийн хоорондын ижилсэх, уусан шингэх, угсаатны шинэ нэгдэл бүрдэх явцаар тодорхойлогддог юм”⁷ хэмээжээ.

Улмаар БНМАУ-ын үндэстэн, ястны талаар тусгайлан тайлбарлажээ. Үүнд, “Манай орны нөхцөл байдал үндэсний асуудал ЗХУ-ын зэрэг социалист бусад орнуудыг бодвол чанарын өвөрмөц онцлогтой байлаа. Энэ нь юуны өмнө тус улсын хүн амын 90 гаруй хувь нь монгол угсаатан, өөрөөр хэлбэл яс үндэс нэгтэй, нийтлэг хэл соёлтой ястнууд байсан тул үндэсний асуудал төдий хурц ээдрээтэй бус байсан юм. Тус улсын **үндэсний цөөнх** болох казах, урианхай, хотон зэрэг **ястан** нь ардын хувьсгалын жилүүдэд аймаг, орон нутгийнхаа эдийн засаг, соёлыг амжилттай хөгжүүлэн социалист монгол үндэстний гэр бүлийн тэгш эрхт гишүүн боллоо. Улсын бага хурлын тэргүүлэгчдийн зарлигаар 1940 онд казах, урианхайн ард түмний хүсэл эрмэлзлийг үндэслэн Баян-Өлгий аймгийг байгуулсан явдал казахын ард түмэнд социализмын замаар үндэсний соёл боловсролоо хөгжүүлэх сайхан боломж нээж өгсөн юм. Орчин үед Баян-Өлгий аймаг хөнгөн хүнсний аж үйлдвэр үлэмж хөгжсөн манай улсын томоохон аймгийн нэг болсон. Тус аймагт ерөнхий боловсролын 24 сургууль ажиллан, үндэсний хэл бичгээр аймгийн “Шинэ амьдрал” сонин болон урлаг утга зохиолын олон ном хэвлэж байна. **Үндэсний цөөнх** нутагладаг аймгуудын намын хороо, гүйцэтгэх захиргаа, орон нутгийн ард олны санал хүслийн дагуу тухайн ястнаар бүрдсэн сум, нэгдлүүд байгуулсан явдал ястнуудын ухамсар дахь урьдын харилцааг хурцатгах бус харин тэдгээрийн хооронд эдийн засаг, соёлын хэлхээ холбоог зузаатган улмаар нэг төвшинд хүргэх, харилцан ойртуулах сайхан боломж олгосон. Ардын хувьсгалын жилүүдэд манай ястнуудын дундаас үндэсний сэхээтэн олноор төрж, тэдгээр нь үндэсний соёл боловсролоо хөгжүүлэх нийгмийн томоохон хүчин болон хувирсны зэрэгцээгээр нийт социалист монголын соёлыг түгээн дэлгэрүүлэгчид

5 Б.Самбуу. Нийгэм судлалын үндсэн ойлголтын товч толь. УБ.,1983.т.129-130.

6 Философийн толь. УБ.,1990.т. 571.

7 С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, III. БНМАУ-ын үндэстний ба угсаатны хөгжлийн асуудалд. (Studia Historica.Tom. 9, Fasc.14,1973).УБ., 2005. т.64.

болсон нь социалист нэгдсэн соёл бүрэлдэн тогтоход сайхан үр нөлөө үзүүлж байна. үүний тод жишээ бол орчин үеийн казахын ард түмний урлаг, утга зохиол, соёл болно”⁸ хэмээн дүгнэв.

Мөн “Угсаатны хөгжлийн нөгөө нэг явц бол ястнууд нэг нь нөгөөдөө шингэн уусах үзэгдэл юм. Хэрэв харилцан ижилсэх явц голчлон угсаа төрөл нэгтэй, **үндэстэн ястнуудын** хооронд явагддаг бол шингэн уусах явц өөр гарал угсаатай үндэстэн ястны хооронд голчлон тохиолддог байна. Зарим үед хоёр өөр угсаатай ястан хэдэн зуун жилийн турш нэг доор хамтран амьдраад нэг нь нөгөөгийнхөө хэл, соёлыг шингээн авсан авч үндэсний ухамсар хэвээр үлддэг байна. Жишээ нь, 1715 оноос дөрвөдийн дотор нутагшин суурьшсан хотон, захчины хэл, соёлыг авсан алтайн урианхай нар хэдийгээр дөрвөд, захчины хэл, соёлыг авсан боловч яс үндсээ хотон, урианхай хэмээн бүртгүүлэн, орон нутгийн биеэ даасан байдлаа хэвээр хадгалсаар байна. Ийнхүү угсаатны нэгдлийн ухамсар он удаан жил хадгалагдан байгаа нь ардын хувьсгалаас өмнө тэдгээр ястнуудын хоорондын харилцаанд улс төрийн тэгш биш байдал, үндэсний дарлал ноёрхож байсны улбаа одоо хүмүүсийн (ялангуяа ахмад үеийнхний) ухамсарт аль нэг хэмжээгээр үлдсэний илрэл юм. Манай орны угсаатан, ястнуудын хөгжил нь халх, казах ястны хэл соёлд тулгуурлан бусад ястнууд эдгээр хоёр ястантай ижилсэх, уусах чиглэлээр хөгжин хоёр том **угсаатны нэгдэл** үүсэн бүрэлдэн тогтож байна. Ийнхүү **социалист үндэстний доторх угсаатны нэгдэл, бүлгүүд** нь социалист байгуулалтын хөгжлийн хурд, өвөрмөц байдлаас шалтгаалан ямар нэг хэмжээгээр байдаг нийгмийн үзэгдэл бөгөөд түүний хөгжлийн хэтийн төлөв үндэсний нэгдсэн нэгдмэл хэлбэр бүрэлдэн тогтоход оршино. Угсаатны ижилсэх, уусах явц нийгмийн хөгжлийн дагуу өөрийн урсгалаар хоцрогдонгуй явагддаг үзэгдэл учир үндэсний хөгжилтэй ангийн бус диалектик зөрчилтэй байдаг”⁹ хэмээн тайлбарласан байна.

Эрдэмтэн С.Бадамхатан дээрэх бүтээлээ хэвлүүлснээс хойш 10 орчим жилийн дараа нэгэн бүтээлээ хэвлүүлсэн нь БНМАУ-ын угсаатны үйл явцыг шинжилсэн дорвилог ажил болсон юм. Уг бүтээлд “Нэг удам угсаатай ястнуудаас **социалист монгол үндэстэн** бүрэлдэн тогтсон манай улсын хувьд үндэсний ба угсаатны асуудал нь нэг ойлголт мэт харагддаг боловч чухамдаа энэ нь хоёр өөр ухагдахуун болно.

Үндэстэн нь түүхийн тодорхой үе, тухайлбал феодалын бутралыг устгасан хөрөнгөтний нийгмийн үед буй болдог бол угсаатан нь хүй нэгдлийн нийгмийн үеэс удам угсааны нийтлэгийн үндсэн дээр үүсэн бүрэлдэж түүхийн хөгжлийн бүх үе шатанд аймаг, ястан гэсэн ухагдахуунаар уламжлагдан байдаг нийгмийн асуудал юм. Үндэстний асуудалд улс төр, нийгэм эдийн засаг, соёлын хөгжил, үндэстнүүдийн хоорондын харилцааны асуудал хамрагддаг бол социализмын үеийн угсаатны явцын асуудалд нийгмийн хөгжлийн ястан угсаатнуудын аж ахуй, соёлд гарч буй өөрчлөлт, тэдгээрийн хооронд ижилсэх явц нь угсаатны шинэ нийтлэгийг буй болгож улмаар социалист үндэстэн, түүний соёл бүрэлдэн тогтоход хэрхэн нөлөөлж буй хэлбэрийг судалдаг болно.

Угсаатны хөгжлийн гол хэмжүүр бол нийгмийн хөгжлийн үр дүнд угсаа гарал өөр буюу нэг угсаатай олон ястан (**угсаатны бүлэг-этническая группа**) нь өөр хоорондоо харилцан ижилсэх, нийлэх гэсэн хоёр үзэгдэл (**консолидация-ижилсэх, ассимиляция-уусах шингэх**) болно” хэмээн нарийвчлан тайлбарласан төдийгүй нөхцөл байдал, жишээ баримтыг дурджээ. Тухайлбал “Манай улсын нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилд хотжих явцыг улам түргэтгэх, хот төв суурин газрууд нь тухайн аймаг орон нутгийн үйлдвэр соёлын төв болж, ийм төв сууринд хүн амын нягтрал өсөж ирсэнтэй холбоотой. Энэ нь юуны өмнө олон угсаа, үндэсний төлөөлөгчид нэг засаг захиргаанд харъяалагдаж үйлдвэр, соёл, шинжлэх ухааны хамт олныг буй болгосон явдал хуучны түгжигдмэл, тусгаарлагдмал амьдралаас ангижруулж, хүмүүсийн ухамсарт овог, яс үндсийг баримтлах үзэл аажмаар алга болж, амьдралын хань түшиг болох

8 С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, III. БНМАУ-ын үндэстний ба угсаатны хөгжлийн асуудалд. (Studia Historica.Tom. 9, Fasc.14,1973). УБ., 2005. т. 62-63

9 С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, III. БНМАУ-ын үндэстний ба угсаатны хөгжлийн асуудалд. (Studia Historica.Tom. 9, Fasc.14,1973). УБ.,2005.т.65-66

хүнээ орчин цагийн нийгмийн хүнийг үнэлэх хэмжүүрээр хэмжин хайр сэтгэлийн үндсэн дээр өрх гэрээ үүсгэн байгуулж байгаа нь хэдийгээр угсаа нэгтэй ч гэсэн яс үндсээр нь бие биенийгээ харь хүмүүс гэж үздэг байсан өнгөрсөн нийгмийн атгаг сэжиг үгүй болж, манай орны олон ястнуудын ижилсэх, нягтран ойртох явц улам гүнзгийрэн хөгжиж байгаагаар тодорхойлогдох болжээ. Айл өрхийн гишүүдийн хооронд ярилцдаг хэл нь халх аялгуунд үндэслэсэн орчин цагийн Монголын утга зохиолын хэл голлож байгаа нь орчин цагийн угсаатны явцын нэг гол шинж юм. Монгол угсаатны бүлгүүдийн хооронд гэр бүл болох явдал цаашид улам өсөх нь манай нийгмийн хөгжлөөс урган гарч байгаа бодит объектив үзэгдэл болно. Үүнд нөлөөлж байгаа хүчин зүйл нь:

1. Манай орны анги давхраа харилцан ойртож, нийгмийн нэг төрөл байдал хөгжиж байгаагаар
2. Орчин үеийн үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл, шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж байгаагийн үр дүнд хүн амын хөдөлгөөн өсч байгаагаар
3. Социалист үйлдвэрлэлийн харилцаа бүрэн төгс ялж, нийт хөдөлмөрчдийн ухамсарт социалист үзэл суртал нэгэнт бүрэлдэн тогтсоноор илэрч байна.

Үйлдвэржсэн хот орон нутагт хүн амын хөдөлгөөн нэмэгдэж, ажилчин ангийн манлайлах роль өсөж, ястнуудын харилцаанд шинэ хэв маягийн харилцаа тогтоож байдаг учир урьдын тусгаарлагдмал байдал, шашин шүтлэгийн бурангуй үзэл санаа арилж, тэгснээрээ социалист үндэстний хөгжлийн хүрээнд явагддаг угсаатны явц түүнд эерэг нөлөө үзүүлж үйлчилж байдаг ёстой билээ “ хэмээсэн нь тухайн үед уг үйл явцыг эрдэмтэд хэрхэн ойлгож дүгнэж байсны бодит илэрхийлэл юм.

Тэрбээр “Казах нь XIX зууны 70-аад оны үед өнөөгийн Баян Өлгий, Ховд аймгийн нутагт суурьшсан бөгөөд одоо (70 гаруй мянган хүн амтай) **социалист монгол үндэстний** нэг хэсэг билээ. Ардын хувьсгалын жилүүдэд казахын ард түмэн МАХН-ын удирдлагын дор аймгийнхаа нийгэм, эдийн засаг, соёлыг амжилттай хөгжүүлж, социалист агуулгатай үндэстний хэлбэртэй соёлоо цэцэглүүлж, эх орныхоо социалист байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Орчин үеийн **казахын угсаатны** хөгжлийн явц нь юуны өмнө казахын ард түмний нийгмийн амьдралаас феодалын үеийн овог, отгийн харилцааны үлдэгдэл бүр мөсөн арилж, казах угсаатны нийтлэг бүрэлдэн тогтсны зэрэгцээ урианхай, мончоого зэрэг түрэг угсааны бүлгүүдийн хооронд ижилсэх явц үргэлжиж байна. Нөгөө талаар казах ардын угсааны хөгжлийн нэг онцлог бол ах дүү монголын ард түмэнтэй тогтоосон угсаа-соёлын олон талын хэлхээ холбоо улам бэхжиж, харилцан нөлөөлөх, баяжих явц улам гүнзгийрч угсаатны интеграци явагдаж байна.

Казах үндэстний хэл дээр сонин сэтгүүл, ном зохиол, уран зохиол хэвлэгдэн нийт олны хүртээл болж байгаа нь казахын үндэстний соёлыг хөгжүүлэхэд үлэмж нөлөө үзүүлж байгаагийн зэрэгцээ монголын утга зохиол соёлтой танилцах, түүнээс сурах, хоёр ард түмний харилцан ойртон нягтрах явцад чухал үүрэг гүйцэтгэж байна. Одоо казахын үндэстний сэхээтэн, нийт хөдөлмөрчдийн олонхи нь монгол хэл эзэмшиж, монгол хэлээр хэвлэгдсэн ном хэвлэлийг чөлөөтэй ашигладаг болсон явдал казахын нийгмийн хөгжилд гарсан цоо шинэ үзэгдэл бөгөөд энэ нь социалист үндэстний хөгжлийн ирээдүйн чиглэлийг тодорхойлогч хүчин зүйл болно.... Орчин үед казахын ард түмэн **төрөлх хэлнийхээ** зэрэгцээ Монголын утга зохиолын хэлийг эзэмшиж, казахын уран бүтээлийн сэхээтнүүд казах, монгол хэл дээр уран бүтээлээ туурвиж байгаа нь Монгол казахын ард түмний соёлыг ойртуулах, баяжуулах сайхан боломж нээж өгч байна. Ер нь аль нэг ард түмэн **хоёр хэл** эзэмшдэг нийгмийн үзэгдэл нь тэрхүү угсааны үндэстний соёлын нөлөөгөөр бус харин соёлын утга агуулга хэлбэрийг улам баяжуулан, угсаатнуудын харилцан ойртох явцыг хурдасгадаг үйл явц юм. Үүнийг казахын ард түмний орчин үеийн үндэстний соёл тод харуулж байна”¹⁰ хэмээсэн нь анхаарал татна.

10 С.Бадамхатан, Эрдэм шинжилгээний бүтээлүүд, III. БНМАУ-ын угсаатны хөгжлийн явц.(Studia Historica.Tom. 8, Fasc.1,1982). УБ., 2005. т.122-127, 135.

Мөн эрдэмтэн Х.Нямбуу бүтээлдээ “Социалист Монгол үндэстэн хэмээх түүхэн шинэ нийтлэг үүсэн төлөвшсөн бөгөөд энэ нь олон төрлийн яс угсааны бүлэгт хамаарагдах хүмүүсийн өвөрмөц нэгдлийг тусгасан нийгмийн нарийн төвөгтэй олон талт үзэгдэл болно. Социалист Монгол үндэстэн төлөвшиж хөгжиж буй үйл явцыг үндсэнд нь хоёр үе шат болгон үзэж болох байна. Нэгдүгээр үе шат нь 1921 оны ардын хувьсгалын ялалтаар эхэлж 1950-иад он сүүлчээр шувтарчээ. Энэ бол **монгол үндэстэн** бүрэлдэн төлөвших улс төр, эдийн засаг, үзэл суртлын урьдач нөхцөл, үндэс суурь бүрэлдэн буй болсон үе юм.

Энэ үед хувьсгалт ардчилсан өөрчлөлт хийж, социализмын үндсийг байгуулах явцад нэгдүгээрт, улс орны нийгэм улс төрийн амьдралд гүн гүнзгий хувьсгалт өөрчлөлт хийж феодалын засаг төр, харилцааг устган, ардчиллыг тууштай хөгжүүлж, ардын ардчилсан төрийг улам бататгаж түүнийг аажмаар ажилчин ангийн диктатур болгон хөгжүүлсэн. Энэ бүхний үр дүнд социалист монгол үндэстэн бүрэлдэх улс төрийн үндэс суурь буй болсон байна. Хоёрдугаарт, феодал ангийн эдийн засгийн хүчин чадлыг сулруулан устгаж, улс орны эдийн засгаас гадаадын орны капиталыг шахан гаргаж, эдийн засгийн засгийн хоцрогдлыг арилгаж, социалист аж ахуйн цоо шинэ системийг буй болгон бэхжүүлэв. 1950-иад оны эцсээр тус орны эдийн засагт бүрэн ялсан үйлдвэрлэлийн социалист харилцаа нь социалист монгол үндэстэн бүрэлдэн төлөвшихөд шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэсэн юм. Социалист Монгол үндэстний гол онцлог бол тэр нь феодалын байгууллын үеийн ястнаас шууд социалист үндэстэн болон цоо шинээр бүрэлдэн төлөвшсөн явдал мөн. Үндэстэн нь өөрөө нийгмийн зүйлийг агуулахын зэрэгцээ угсаатны зүйлийг мөн нэгэн адил багтаадаг юм. Социалист Монгол үндэстний бас нэг онцлог нь тэрээр үндсэндээ монгол угсааны ястнуудаас бүрэлдэж байгаад оршино”¹¹ хэмээн тодорхойлжээ.

Мөн 1983 онд хэвлэгдсэн “Хүүхэд-залуучуудын нэвтэрхий толь”-д “Нийгмийн ба үндэсний бүрэлдэхүүн...Манай улсад хэлний хоёр бүлэгт багтах **угсаатан ястан** оршин сууна. Үүний 90 гаруй хувийг монгол хэлтний бүлэгт багтах халха, баяд, барга, буриад, дариганга, дархад, дөрвөд, захчин, мянгад, өөлд, торгууд, үзэмчин, хамниган, харчин, хотгойд, цахар эзэлдэг. Хэлний хоёр дахь бүлэгт турк хэлтэн казах, урианхай, хотон багтана. Казахууд тус улсын хүн амын 4,6 хувийг эзэлдэг. Монгол орны эдгээр угсаатан, ястан Үндсэн хуулиар хангагдсан бүрэн эрх эдэлж, нийгэм, улс төр, эдийн засаг, соёл боловсролын үйл хэрэгт адил тэгш эрхтэй оролцдог юм” хэмээн бичсэн. Мөн “Ардын хувьсгалын дараа МАХН марксист-ленинист үндэсний бодлогыг тууштай баримтлан казах, урианхайн **үндэсний цөөнхийн** ард олонд улс төрийн эрх чөлөө олгохын зэрэгцээ тэдний аж ахуй, соёлын хоцрогдлыг арилгахад чиглэсэн томоохон арга хэмжээ удаа дараа авч явуулсан билээ”¹² хэмээн тэмдэглэжээ. Энэ нь тухайн үед “угсаатан”, “ястан”, “үндэсний цөөнх” зэрэг ойлголт олон нийтийн дунд нэмэлт тайлбаргүйгээр түгээмэл хэрэглэгдэж байсныг илтгэнэ.

Иймд 1990-ээд оноос өмнөх үед “үндэстэн” болон “угсаатан” хэмээх нэр томъёо нь агуулгын хувьд хувиран хэрэглэгдэж иржээ. Үүнд тухайн үеийн ЗХУ-ын нөлөө багагүй байсныг эрдэмтэн судлаачид цохон тэмдэглэсэн байдаг. “Үндэсний цөөнх” хэмээх нэршил нь бидний олж үзсэнээр, судалгааны бүтээлд 1970-аад оноос, олон нийтэд зориулсан толь бичигт 1980-аад оноос хэрэглэгдэж байсан байна. Харин 1924, 1940, 1960 оны “Үндсэн хууль”-д уг нэршлийг дурдсангүй ажээ.

11 Х.Нямбуу. Монголын угсаатны зүй. Удиртгал.УБ., 1992.т. 62-63.

12 Хүүхэд-залуучуудын нэвтэрхий толь. I. УБ.,1983. т.101-102, 80.

II. 1990 оноос хойшхи үед үндэстэн болон угсаатан хэмээх нэр томъёог хэрхэн тэмдэглэж, тайлбарлаж байгаа талаар товч танилцуулъя.

1992 оны “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 1-р бүлгийн 8-р зүйлийн 1-д “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн”, 2-д “Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий **үндэстний цөөнх** эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө”, 2-р бүлгийн 14-р зүйлийн 2-т “Хүнийг **үндэс, угсаа**, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”¹³ хэмээн тус тус заажээ. Ийнхүү тус хуулинд “үндэстний цөөнх”, “үндэс”, “угсаа” хэмээх нэр томъёог бичихдээ өмнөх “Үндсэн хууль”-д буй зарим нэр томъёог хэрэглэсний дээр шинээр томъёолжээ.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолын хавсралт **“ТӨРӨӨС СОЁЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГ”-ын** 3.1.3-д “монгол үндэстэн, үндэстний цөөнхийн өв соёл, түүх, ёс заншлыг тэгш хүндэтгэн, хадгалж хамгаалах” хэмээн заажээ. Мөн 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр баталсан **“МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ” хуулинд** “13.1.5.үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах” хэмээн заасан байдаг.

Мөн 1992 оны “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 1-р бүлгийн 10-р зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”¹⁴ хэмээсэн байдаг. Иймд ЮНЕСКО-гийн зарим баримт бичиг дэх “үндэстний цөөнх” хэмээх тэмдэглэлийн нягтлан үзье.

2000 оны 4-р сарын 26-28-нд Сенегал улсын Дакар хотноо хуралдсан Боловсролын олон улсын чуулганаас баталсан “Дакарын үйл ажиллагааны хүрээ” (Dakar Framework for Action) баримт бичгийн 7-р зүйлийн 2-рт “Бүх хүүхдүүд, ялангуяа охидууд, эмзэг бүлгийн болон үндэсний цөөнхийн хүүхдүүдийг 2015 он гэхэд албан журмын, үнэ төлбөргүй, чанартай бага боловсролд хамруулж, эзэмшүүлэх”¹⁵ хэмээн заажээ. Харин уг баримт бичгийн англи хувилбарт “ethnic minority” хэмээснийг “угсаатны цөөнх” хэмээн орчуулж болох талтай.

Эхлээд “үндэстэн” хэмээх нэр томъёог олон улсад хэрхэн тодорхойлдгийг авч үзье.

“Үндэстэн (nation)” хэмээх нэр томъёоны тодорхойлолтын талаар судлаачид өнөөг хүртэл нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна. Нэгдмэл цогц байдлын үр дүн, нэр томъёонд хэрэглэж байгаа орцуудын шинж чанараас тодорхойлолтын үндсэн шинж чанар бүрдэж буй тул маргаантай хэмээн үздэг. Хүн төрөлхтөн олон ялгаатай соёлуудын төрөл (хэл, хувцас, итгэл үнэмшил гэх мэт бүлгүүдээр ялгагддаг) улс төрийн олон хэсгүүдэд (харилцан туслалцах сан, дэмжих бүлэг, нэг засаг захиргаатай байх гэх мэт зүйлүүдэд) хуваагддаг. Соёлын болон улс төрийн хүрээ хязгаарууд ерөнхийдөө тодорхой байдаг. Гэвч соёлын онцлог шинж болох хэл, шашны баримтлал болон зан заншил нь иргэдийг хоорондоо зөрчилдөхөд хүргэдэг. Иймд улс төр, соёлын хүрээ хязгаарууд нь давхцах нь ховор байдаг.

Улс төрийн болон соёлын хувьд ялгаатай бүлгүүдэд “үндэстэн” (nation) хэмээх нэр томъёог хэрэглэх боломжтой байдаг. Түүхэн улс төрийн том, жижиг олон нэгжүүдийг ерөнхийдөө “Үндэстнүүд” хэмээдэг. Хэдийгээр улс төрийн нэгжүүд бусдын хүсэл зорилгоор тодорхойлогддог, өөрсдийн гишүүдээр зөвшөөрөгдсөн, заримдаа холимог соёлтой байсан ч “Үндэстэн” гэж нэрлэгддэг. Үүний нэг жишээ Швейцарь үндэстэн юм. Тэд соёл, хэл зүйн хувьд ялгаатай ч гэсэн улс төрийн бодлогод ач холбогдол өгдөг дэд бүлгүүдээс бүрддэг. Гэвч соёлын ялгаатай л бол “Үндэстэн” гэж ойлгож болохгүй. Арабууд хэл аялгуугаараа ялгаатай тул харилцан ойлголцдоггүй. Гэхдээ тэд Араб үндэстний ухамсраар нэгдэлтэй байдаг.

13 Монгол Улсын Үндсэн хууль. УБ.,1992.т. 5, 7.

14 Мөн тэнд. т.5-6.

15 Баримт бичгийн эмхтгэл. ЮНЕСКО-гийн Тунхаглал, Конвенц, Зөвлөмж.УБ.,2005. т.44.

Соёлын, улс төрийн өв нь цогц бөгөөд хувьсах шинжтэй. XVIII-XIX зууны үеэс хойш “Үндэстэн” (nation) гэх асуулт нь нийгэм, улс төрийн байгууллагуудын хүрээнд дэлгэрч, анхаарал татах болсон юм. Энэ төрлийн нийгмийн шинж чанар нь газар тариалангийн эдийн засгийн сууриа аж үйлдвэрийн эдийн засгаар сольсонтой холбоотой. Газар тариаланд ажиллагсад нийт ажиллах хүчний бага хувийг эзлэх болж, аажмаар цөөнх болов. Цаашлаад нилээд хугацааны дараа нийт хүн амын энэхүү хэсэг нь илэрхий ялгаатай болж эхэлсэн байна. Ихэнх ажил хөдөлмөрийн шинж чанар өөрчлөгдөж, биеийн хүчний ажлаас илүүтэйгээр оюун ухаан шаардсан ажил шаардагдах болов. Ажлын шинж чанар (нэр нь үл мэдэгдэх холбоонд ихэнхдээ олон танихгүй хүмүүсийн хамт татагдан оролцох), нийгмийн харилцааны мөн чанар нь олон улсад бичиг үсгийн болон албан боловсролоор хэмжигдэж эхэлжээ. Тэрхүү нөхцөлд хамтын хэрэглээний болон стандартлагдсан боловсрол нь нийгмийн ижилсэлийн гол шалгуур болох соёл дээр суурилдаг ажээ. Төрийн гол үүргүүдийн нэг бол ийм соёлыг хэвээр хадгалах, хамгаалахад явдал болжээ. Хүн төрөлхтөн өөрийн бичиг үсгийн соёлыг тогтоосноор оршин тогтнодог бол төр нь эдгээр соёлуудыг хамгаалдаг байна.

Иймд “Үндэстэн” (nation) гэх ойлголт нь өөр хоорондоо соёл, хүсэл эрмэлзэл, улс төрийн хамаарлаар холбогдсон хүн ам юм. Үндэсний ижилсэл нь ерөнхийдөө санаа бодол, улс төрийн хууль ёсны шалгуур болжээ. Соёлын шингэн уусах үйл явцын гадаад шалгуур ба улс төрийн субъектив шалгуурын аль алин нь энэ тодорхойлолтод илэрхийлэгдсэн боловч тэдний хувийн жин янз бүр байдаг. Жишээ нь, Швейцарь улс нь соёлоос илүүтэйгээр хамтын хэрэглээгээр тодорхойлогддог.

Нөгөө талаар дээрх тодорхойлолтын хэрэглээ маргаантай хэвээр байдаг. Тодорхойлолтын “Үндэстэн-төр” бий болоход анхаарлаа хандуулдаг тул зөвхөн улс төрийн, эсвэл соёлын холбоонд тулгуурласнаар зөрчил үүсдэг. “Үндэстэн” хэмээх нэр томъёо нь орчин үеэс өмнө дундад зууны их сургуулийн оюутнууд, тухайн улс төрийн баян чинээлэг хүмүүст (Польш) бүс нутгийн тухай тайлбарлах үед хам сэдэв болон гарч байсан түүх бий. Гэвч аливаа тодорхойлолтоор орчин үеэс өмнөх бүлгүүд үндэстэн болсон эсэхийг хангалттай нотлох боломжгүй. Иймд “үндэстэн” хэмээх нэр томъёог тодорхой зорилготойгоор авч үзэх нь зүйтэй ажээ.¹⁶

Смитийн тодорхойлсноор **“Угсаатан”** нь нийтлэг нэр, нэгэн өвөг дээдсийн тухай домог, түүхэн ой санамж, соёлын онцлог элементүүд, тухайн газар нутагтай холбоотой байдал, нийгмийн нэгдлийн тухай мэдрэмж зэрэг шинжийг агуулсан нэгдэл ажээ.¹⁷ XX зуунд Монголд угсаатан, үндэсний үзлийг бүтээсэн болон 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд туссан үндэстний асуудлын талаар эрдэмтэн Урадын Э. Булаг зохиолдоо тэмдэглэсэн байдаг.¹⁸

Мөн эрдэмтэн Дэвил Снийт илтгэлдээ “Социализмын дараах үеийн эдийн засаг, нийгмийн хямралын үед харилцан туслалцах сүлжээг тодорхойлохын тулд бүлгийн ижилслийн бүхий л төрлийг ашигласан байдаг. Ястны бүлэгт хамрагдах хүмүүсийн зарим хэсэг нь тодорхой хэмжээнд харилцан холбоотой, нэгдсэн үндэс гарвалтай байдаг. Гэвч ихэнх монголчууд өөрсдийн угсаатны гарвал хамаарлын асуудлаас илүү нутгийн ижилсэлд түлхүү анхаарал хандуулдаг байна. Өнөөдрийг хүртэл үндэстнийг хамарсан угсаатны сөрөг зохион байгуулалт гараагүй байна”¹⁹ хэмээн дүгнэжээ.

Цөөнхийн талаарх томъёоллыг тодруулан үзье. Зарим судлаачдын үзсэнээр, цөөнхүүдийн минимум стандартыг хэрэгжүүлэхдээ

16 The Blackwell Dictionary of Twentieth-Century Social Thought. Editors: William Outhwaite, Tom Bottomore. Advisory editors: Ernest Gellner, Robert Nisbet, Alain Touraine. Reprinted 1995, 1997, 1998. Blackwell Publishers Ltd. Oxford. UK. p.402-403.

17 Урадын Э.Булаг. Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил. УБ.,2016. т.25.

18 Мөн тэнд.т.25-93.

19 Дэвид Снийт. Монголын социализм ба социализмын дараах ижилсэл//Социализмын дараах Монголчууд: Улс төр, эдийн засаг, шашин. УБ., 2012.т.173.

1. Боловсрол, хэлний асуудал, шашин шашингүйн үзэл
2. Ажил эрхлэлт, газар нутгийн эрхүүд, байгалийн нөөц баялаг
3. Хүмүүсийн бие даасан байдлын хамгаалалт
4. Сайн нягт харилцаа холбоог дэмжих хөтөлбөрүүдийг хамруулдаг.

Төр ба цөөнхүүдийн аль нь ч боловсролын эрхийг байнга онцолж үздэг. Үүнийг боловсролын тогтолцоонд нэвтрүүлснээр үндэсний нэгдэл, ялгарах шинж (identity)-ийн хувьд зохих ач холбогдолтой. Иймд бүх нийтийн боловсролын тухай хуулийн тунхаг гаргахдаа цөөнхийн эрхийг тусгадаггүй. Энэ хандлага нь цөөнхийн шашин, хэл, сургалтын хөтөлбөрүүдтэй хамаатай онцлог эрхүүдийн үзэлтэй ихэвчлэн зөрчилддөг. Цөөнх боловсролыг өөрсдийн ирээдүйн хэтийн төлөв, түүнчлэн өөрсдийн үнэт чанар, соёлыг дамжуулдаг хамгийн нэн чухал зүйл гэж үздэг. Мөн Жеймс Чин, Давид Хавк, Петр Онейл (James Chin, David Hawk and Peter O'Neill) нар Монгол улсын баруун бүсэд олноор амьдардаг казахууд нь Монголын **угсаатны бүлэг (ethnic group)**-т хамаарагддаггүй. Монголчуудын цөөнх буюу казахуудын талаар ямар нэгэн онцгой асуудлууд тэмдэглэгдээгүй. Тус улсын цөөн хүн ам өргөн уудам нутагт тархсан. Иймд өөр өөр бүлгүүдийн хувьд тэдний ялгагдах байдал, өөрсдийн үзэл бодлыг таниулахад мэдээллийн бүтэц (information structure) чухал²⁰ хэмээн бичжээ.

1990-ээд оноос хойш нийгмийн ухааны нэр томъёоны тайлбар толиуд цөөнгүй хэвлэгдсэнээс жишээ болгон дараах толь бичгийн тайлбарыг танилцуулъя.

2006 онд Нээлттэй нийгэм форум, НҮБХХ-ийн хамтарсан санхүүжилтээр хэвлүүлсэн “Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь”-д **“Үндэстэн** хэмээх нэр томъёо нь хос утгыг агуулна. Нэгд, хуучинсаг утгаараа тогтвортой байдлыг, өөрөөр хэлбэл аль нэгэн үндэс язгуур нэгтэй угсаатны бүлэгт хамааралтай байхыг хэлнэ.

Энэхүү үндэстэн гэдэг нь тодорхой төрлийн нэгдмэл шинж тэмдгүүдийг (нэг хэл яриа, соёл, түүх) өөртөө агуулсан, нэг нутаг дэвсгэр дээр оршин суух отог омгийн нийгэмлэг юм. Хоёрт, илүү нээлттэй байдлаар тайлбарлавал **үндэстэн** гэдэг нь хувьсан өөрчлөгдөх, хөгжин дэвших боломжийг нэрийднэ. Энэхүү боломж нь нэг улс хэмээх том бүлгийн дотор хамтран амьдарч, хоорондоо ижил төстэй болон тэс өөр шинж тэмдгүүдийг агуулсан, иймээс ч янз бүрийн яс үндэс, угсаа гаралтай хүмүүсийн тэрхүү соёл нь хоорондоо холилдож, өөрчлөгдөн хөгжих боломж болдог. Өөрөөр хэлбэл, угсаа язгуурын бус, харин харилцан хамааралтай байх сэтгэлгээтэй бүлэг хүмүүсийг үндэстэн хэмээн нэрийднэ. Энэхүү нээлттэй байдлыг илтгэх тайлбар нь өнөөгийн ардчилсан нийгмийн тухай ойлголтод илүүтэй нийцнэ. Газар нутгийн хүчин зүйлийг авч үзвэл, улсгүй (өөрийн нутаг дэвсгэргүй) үндэстэн (жишээ нь курдууд) болон улсын үндэстэн (өөрийн нэгдмэл нутаг дэвсгэртэй) хэмээн ангилж болно. Яс угсаа, гарлаас илүүтэйгээр улс төрийн элементүүд нь үндэстний нийгэмлэгийг тодорхойлж байдаг болох тийш хөгжих зүй тогтолтой юм”²¹ хэмээн бичжээ.

Харин **“Цөөнх”** хэмээх нэр томъёог “Суурь утгаараа цөөнхи гэдэг нь тухайн нийгэм дэх үндэстэн ястан, шашин шүтлэг, хэл соёл, арьс өнгө зэрэг язгуур болон орлого, боловсрол зэрэг нийгэм –эдийн засгийн бий болдог ялгарлаар тооны хувьд цөөн бүлэг хүмүүсийг хэлнэ. Тодорхой үзэл бодол, гарах шийдвэрийг дэмжсэн хүчний харьцаа эсвэл парламент дахь намын эзэлж буй суудлын тоогоор мөн цөөнхийг тодорхойлно. Гагцхүү, ардчилал болон цөөнхийн эрхийг хамгаалсан олонхийн засаглал гэдэгт тоон үзүүлэлтээс үл хамааран цөөнхи болон тэр бүлэг хүмүүсийн ашиг сонирхлыг илэрхийлэхийг ойлгоно”²² хэмээн тайлбарлажээ.

Мөн Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос хэвлүүлсэн “Хүний эрхийн товч тайлбар”-т **“Үндэстний цөөнхийн эрх (National minority rights)”** хэмээх нэр томъёог

20 World Directory of Minorities. Edited by Minority Rights Group International, United Kingdom, London, 1997.p.X, 632.

21 С.Баяраа, Д.Ганбат, Ч.Ган-Өлзий, А.Саруул, Д.Төмөртоогоо, Г.Чулуунбаатар. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь.УБ., 2006.т. 132.

22 Мөн тэнд.т.147.

“Угсаатан, шашны ба хэлний цөөнх оршдог орнуудад эдгээр цөөнхөд багтдаг хүмүүст тухайн цөөнхийн бусад гишүүний хамтаар өөрийн соёлыг эзэмших, шашнаа шүтэх, ёслолоо үйлдэх, түүнчлэн эх хэлээрээ ярих эрхийг хорьж болохгүй. (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 27 дугаар зүйл) **Үндэстний цөөнх** гэдэг нь тухайн улсын хүн амын дийлэнхтэй харьцуулахад тооны хувьд цөөнх болох хэл, арьсны өнгө, соёл иргэншлийнхээ хувьд ялгарах өөрсдийн өвөрмөц байдлыг хадгалах хүсэл эрмэлзэл бүхий тодорхой бүлэг хүмүүсийг хэлнэ.

Ихэнх улс оронд угсаатны болон хэлний цөөнх бий. Тэдний амьдралын хэв маяг, хэл соёл болон үндэс угсаа нь олонхиос ялгаатай. Цөөнхийн нийгэмд эзлэх байр суурийг дан ганц тооны харьцаагаар тооцохгүй, мөн тэдний улс төрд эзлэх эрх мэдлээр тодорхойлно. Зарим газруудад, тухайлбал арьс өнгөөр ялгаварлан гадуурхдаг Өмнөд Африк дахь үндэсний цөөнх нь өөрөө тооны хувьд олонх ч эрх мэдлийн цөөнхийн бүлгийг бүрдүүлдэг. Түүнчлэн “уламжлалт” (удаан хугацааны оршин суугч) цөөнхөд цагаачид, уугуул иргэд болон өөрсдийн газар нутаггүй нүүдэлчид орно. Олон улсын эрх зүйд үндэстний (угсаатны) цөөнх гэх нэгдсэн нэг тодорхойлолт байдаггүй. Гагцхүү Европын бүсийн болон Цөөнхийн хэлний тухай Европын тунхаг болон Европын Зөвлөлийн Парламентийн Ассемблейн Тогтоол 1201(1993 оны)-д тодорхойлсон байна. Гэсэн ч онолын хувьд **үндэстний цөөнх** гэж дараах бүлэг хүмүүсийг хэлнэ. Үүнд:

1. Тухайн улсын бусад хүм амаас тооны хувьд бага
2. Дийлэнх байр суурийг эзлээгүй
3. Тухайн улсын хүн амын олонхоос соёл, хэл, шашин шүтлэг, арьс өнгө зэргээр ялгаатай
4. Цөөнхийн бүлгийг гишүүд нь тухайн амьдарч буй орондоо цөөнх гэсэн нийгмийн байр суурьтай бөгөөд тухайн улсынхаа иргэншилтэй
5. Удаан хугацааны туршид тухайн газар нутагт амьдарч ирсэн хүмүүсийг хэлнэ.

Олон улсын хүний эрхийн эрх зүйд үндэстний олон угсаатны цөөнхийн эрхийг хэд хэдэн аргаар хамгаалдаг ба үүний нэг өөрийгөө тодорхойлох эрх юм. Үндэстний (угсаатны) цөөнхийн эрхийг хамгаалдаг байдлаараа Европын орнууд дээгүүр ордог. Монгол улсад үндэстний цөөнхийн 2 том төлөөлөл оршин амьдардаг ба казах, тува (цаатан) үндэстнүүд өөрийн хэл, соёл, зан заншил, шашин шүтлэг, угсаатны цөөнхөө өнөөдрийг хүртэл хадгалж ирсэн байна”²³ хэмээн тодорхойлжээ. Уг баримт бичгийн англи хувилбарт “rights of national minorities” хэмээн бичсэнийг “үндэстний цөөнхийн эрх” хэмээн орчуулсан байна. Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар бүтээсэн монгол хэлний цахим тольд “үндэстний цөөнх” хэмээх нэр томъёог “нэг улсад харьяалагдах олон үндэстнүүдээс цөөн тоотон хүмүүс” хэмээн тайлбарлажээ.

Дээр дурдсан зарим баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлавал, 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль дахь **“үндэстний цөөнх”, “үндэс”, “угсаа”** зэрэг нэр томъёо нь улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээний өөрчлөлт, олон улсын гэрээний нэр томъёотой уялдсан шинэ утга агуулга бүхий болсон ажээ. Мөн олон улсын бичиг баримтад томъёолсон байдлыг ерөнхийлөн авч үзвэл, НҮБ (ЮНЕСКО)-ийн баримт бичигт **“угсаатны цөөнх”** хэмээх нэр томъёог, Европын холбооны баримт бичигт **“үндэстний цөөнх”** хэмээх нэр томъёог хэрэглэдэг. Монгол улсын холбогдох хууль тогтоомжид “үндэстний цөөнх” хэмээх нэр томъёог албан ёсоор хэрэглэсэн байна.

*Боловсруулсан: Л.Алтанзаяа, Доктор,
МУБИС-ийн Нийгэм, Хүмүүнлэгийн ухааны сургуулийн багш*

²³ Г.Агар-Эрдэнэ ба бусад. Хүний эрхийн товч тайлбар. УБ., 2012.т. 142-143.

